

## Маргааны товч

Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 487 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”-д төрийн үйлчилгээний албан тушаал болох “багийн нийгмийн ажилтан”-ы албан тушаалыг төрийн захиргааны албан тушаалд хамааруулан төрийн захиргааны албан тушаалын ангиллыг “Туслах түшмэл”, зэрэглэлийг “ТЗ-10” болгон тогтоосонтой холбогдуулан Баян-Өлгий аймгийн Өлгий сумын Засаг даргын Тамгын газрын дарга тус сумын 8 дугаар багийн нийгмийн ажилтан Т.Өмиржаныг “төрийн албаны тусгай шалгалтад тэнцээгүй” үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлжээ.

Нэхэмжлэгчээс “багийн нийгмийн ажилтны ажил үүрэг өөрчлөгдөөгүй, төрийн үйлчилгээний албанаас төрийн захиргааны алба болон өөрчлөгдсөн нь төрийн албаны тусгай шалгалт өгөх, ажил үүрэг өөрчлөгдөх болон миний ажилдаа тэнцэхгүй байх үндэслэл болохгүй” гэх үндэслэлээр маргасан.